

хэмээх урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулсан байна.

Бид ирэх дөрвөн жилд засаглалын хямралыг арилгаж улс төрийн тогтвортой байдлыг хангаж, Говь-Алтайчуудын нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлж, хүний хөгжлийг дэмжсэн, эдийн засгийн өсөлтийн үр шимийг иргэн бүрд бодитой хүргэх цогц бодлого хэрэгжүүлнэ.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь 5 Бүлэг 21 дэд бүлэг 268 арга хэмжээнээс бүрдэнэ.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Орлоготой - Алтайчууд
- 1.2. Орон сууцтай - Алтайчууд
- 1.3. Эрүүл - Алтайчууд
- 1.4. Дэлхийн боловсрол - Алтайд
- 1.5 Хүмүүнлэг-Алтайчууд
- 1.6 Үндэсний бахархал, өв соёл, спорт

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО


- 2.1.Хөгжилд хөтлөх мега төсөл, хөтөлбөрүүд
- 2.2.Эдийн засгийн төрөлжилт
- 2.3.Дэд бүтцийн сүлжээ
- 2.4.Алтайн баялгийн сан
- 2.5.Гадаад харилцаа хамтын ажиллагаа

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1.Шударга ёсны засаглал
- 3.2.Цахим Алтай – хүнд сурталгүй төрийн үйлчилгээ
- 3.3. Мэргэшсэн ёс зүйтэй төрийн алба

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1.Баталгаат ундны ус
- 4.2.Хариуцлагатай уул уурхай
- 4.3.Хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт
- 4.4.Ногоон эдийн засаг – Эко Алтайчууд



ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1. Амьдралын таатай орчин бүхий ногоон Алтай
- 5.2. Эдийн засгийн бүсчилсэн хөгжил
- 5.3. Аймгийн хөгжил сумаас
 - 5.3.1 Алтай сум
 - 5.3.2 Баян-Уул сум
 - 5.3.3 Бугат сум
 - 5.3.4 Бигэр сум
 - 5.3.5 Дарив сум
 - 5.3.6 Дэлгэр сум
 - 5.3.7 Жаргалан сум
 - 5.3.8 Тайшир сум
 - 5.3.9 Тонхил сум
 - 5.3.10 Төгрөг сум
 - 5.3.11 Цогт сум
 - 5.3.12 Цээл сум
 - 5.3.13 Чандмань сум
 - 5.3.14 Халиун сум
 - 5.3.15 Хөхморьт сум
 - 5.3.16 Шарга сум
 - 5.3.17 Эрдэнэ сум
 - 5.3.18 Есөнбулаг сум

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орлоготой - Алтайчууд

- 1.1.1. Сумын төвд ажлын байрууд бий болгох зорилтын хүрээнд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамруулж, өрхийн бичил бизнесийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хувийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хүний хөгжлийн төв” –үүдийг байгуулна.
- 1.1.2. Орлого багатай өрхийн насанд хүрсэн ажил эрхлээгүй гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.3. Алтайд үйл ажиллагаа явуулж буй томоохон компаниудын хоол хүнс, хувцас хэрэгсэлийг орон нутгаас хангах, ажиллах хүч, туслан гүйцэтгэгчийг жижиг дунд бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.4. Ахуйн үйлчилгээний явуулын бригад бий болгож сумын ард иргэд, малчдад үйлчилгээг ойртуулна.
- 1.1.5. Орон нутаг үйл ажиллагаа явуулж буй томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс дэмжлэгтэйгээр өрхийн хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.6. “Алтайн–Малчин” хөтөлбөрийг төгөлдөржүүлж, малчдын залуу халааг бэлтгэх, уламжлалт мал маллагааны арга барилыг шинжлэх ухаан технологийн хөгжилтэй уялдуулж мэдлэгтэй малчин бэлтгэх, ажлыг МСҮТ-тэй хамтран хэрэгжүүлж МАА-н нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлж, малчин чанар ашиг шимийг сайжруулах ажлыг хийж малчдын орлогыг бодитойгоор нэмэгдүүлнэ.

1.2. Орон сууцтай – Алтайчууд

8217144139
ДЮА0060 9015 301

- 1.2.1 Анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд бага хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлд хамруулна
- 1.2.2 “Алтай орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөтгөж, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 1000 өрх, айлыг орон сууцанд орох боломжийг бий болгоно.
- 1.2.3 Иргэдийн бүлэг, СӨХ-ийн санал санаачлагыг урамшуулан дэмжиж, үйл ажиллагаа явуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлж орон нутгийн хөгжил, орчны тохижилт бүтээн байгуулалтад татан оруулах ажлыг төрийн зүгээс санаачлан дэмжин ажиллана.
- 1.2.4 Солонго хороололд баригдах 2788 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцээж ашиглалтад оруулна.

1.3. Эрүүл-Алтайчууд

- 1.3.1 Эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлж, орон сууцжуулах бодлогыг орон нутгийн төр захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.3.2 Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний хэрэглээг хязгаарлаж, халдварт бус өвчний эрсдэлд хүчин зүйлийг бууруулна.
- 1.3.3 Орон нутгийн эмч, эмнэлэгийн ажилтны хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношлогооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, дасгал хөдөлгөөн, зөв хоололт, стресс бухимдлаас ангид байх эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгож, эмийн бус аргаар эрүүлжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн өвчнийг эрт үед нь илрүүлэх товлалт үзлэг оношлогоо, шинжилгээнд жил бүр заавал хамруулах тогтолцоог бүрдүүлж, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн эрт илрүүлэг, зөвлөгөө хяналт, андрологи, үргүйдэл, цэвэршилтийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээг байгуулан бэлгийн замаар дамжих халдварын тусламж үйлчилгээг нөхөн үржихүйн, эсэн мэнд амаржихуйн болон өсвөр үеийн тусламжтай уялдуулсан байдлаар зохион байгуулах, үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 1.3.6 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал тухайлбал, үер, зуд, ган, газар хөдлөлт, түймэр гэх мэт байгалийн давагдашгүй хүчин зүйл, шинэ болон сэргэн тархаж буй өвчний дэгдэлт, Ковид-19, томуу, томуу төст өвчний үед эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэн ажиллана.
- 1.3.7 Аймагт Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулж, бэхжүүлэх ажлыг ээлж дараатай шийдвэрлүүлнэ.
- 1.3.8 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийн хүрээнд “Хавдаргүй- Алтайчууд” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.9 “Эрүүл шүд- Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг / ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл - ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл хүүхэд – Алтайн ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.10 Мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарыг эмчлэх, эрүүл мэнд, сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх нэгж байгуулна.


- 1.3.11 Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэд 50 ортой хүүхдийн эмнэлгийн шинэ барилга барьж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.
- 1.3.12 Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г бүх сумдад зохион байгуулж ажиллана
- 1.3.13 Сумдын эмнэлэгийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг ээлж дараатай хийж дуусгахын зэрэгцээ яаралтай тусламжийн орон нутгийн чадавхыг дээшлүүлж, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, сумдын Эрүүл мэндийн төвийг түргэн тусламжийн дуудлагын 2 автомашинтай болгох замаар хөдөөгийн ард иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулна.

1.4 Дэлхийн боловсрол - Алтайд

- 1.4.1 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Алтайн-Чадварлаг багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.2 БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН-ыг барьж ашиглалтанд оруулж орчин үеийн дэвшилтэт технологиор хангах ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.4.3 Орон нутаг, бүс, улс, олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш нарыг дэмжиж, урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.4 Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийг түшиглэн баруун бүсийн үзлэг оношлогоо, судалгаа шинжилгээний төв болгон хөгжүүлнэ.
- 1.4.5 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн баруун бүсийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх политехникийн сургууль болгон хөгжүүлнэ.
- 1.4.6 Сургууль, цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
- 1.4.7 Ерөнхий боловсролын сургуулиудыг байгалийн ухааны лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж боловсролын чанар, үр өгөөжид анхаарч ажиллана.
- 1.4.8 Алсын зайн сургалт, онлайн шалгалт явуулах орчин нөхцөл бүрдүүлж, тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.4.9 Элсэлтийн ерөнхий шалгалт, хөндлөнгийн үнэлгээ, сургалтын чанараас хамаарч багш, сурагчдыг урамшуулах журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.10 Нүхэн жорлонтой бүх цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 1.4.11 Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд орчин үеийн шинжлэх ухааны дэвшил болон амьдралын зохист хэвшлийн талаарх сурталчилгааг өргөжүүлнэ
- 1.4.12 Сурагчдын авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлан, “Залуу зохион бүтээгч”, “ШБОС-ын эзэн”, “Хөдөлмөр зуслан”-уудыг хичээллүүлэн үйл ажиллагааг нь тогтмолжуулна.
- 1.4.13 Багш ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна

1.5 Хүмүүнлэг-Алтайчууд

- 1.5.1 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоож, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.



- 1.5.2 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, тусгай хэрэгцээг хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настангуудын эмчилгээ, асаргаа, сувилгаа зэрэг эрүүл мэнд болон нийгэм хамт олонд түшиглэсэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэд “Хүний хөгжлийн ордон” барьж ашиглалтанд оруулна.

Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр


- 1.5.3 Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5.4 Цахим орчны соёлтой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр дэд хөтөлбөр боловсруулж, хүүхэд залуучууд ард иргэдийг кибер халдлагад өртөхөөс сэргийлж, цахим орчинд эерэг хандлагыг төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.5.5 Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалалын тогтолцоог бэхжүүлж хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгаалалын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.6 Аймгийн төвд болон сумдад хүүхдийн парк байгуулж хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, тэдний чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх орчныг бүрдүүлнэ.

Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.5.7 Залуучууд, залуу гэр бүлийг орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.8 Хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн “Алтайн баялаг–Залуус” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.5.9 Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвүүд байгуулна.
- 1.5.10 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Залуу гэр бүл" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.11 Алтайн ирээдүй болсон залуучуудыг байгаль нийгэмдээ хандах эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор хүүхэд залуучуудын хүсэл сонирхлын бүлгийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж, орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.5.12 “Цалинтай ээж” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгох бодлогыг дэмжинэ.

Тусгай хэрэгцээ/хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих чиглэлээр.

- 1.5.13 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)- тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.5.14 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцөлийг төрийн болон бусад бүх байгууллагад бүрдүүлнэ.
- 1.5.15 Байнгын асаргаа шаардлагатай тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд, ахмадуудад зориулсан төрөлжсөн асрамж, сувиллын үйлчилгээний тогтолцоог сайжруулна.
- 1.5.16 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамираар хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох нөхцлөөр хангана.



Ахмадуудад үзүүлэх үйлчилгээний чиглэлээр

- 1.5.17 “Насны хишиг” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.5.18 Тэтгэврийн зөрүүг ойртуулах цогц арга хэмжээ авч, тэтгэврийн дээд, доод, дундаж хэмжээний зохистой харьцаа тогтоох бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.5.19 Тэтгэврийн шинэчлэл хийж, нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх хууль батлагдсан нөхцөлд орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.5.20 Ахмадын нийтийн тээвэр, амралт, сувиллын хөнгөлөлт, хүнсний талон зэрэг тусламж үйлчилгээний зардлыг хувь хүний тэтгэврийн дансанд шилжүүлдэг тогтолцоог бий болгоно.
- 1.5.21 Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвийг байгуулна.

1.6 Үндэсний бахархал, өв соёл, спорт


- 1.6.1 Дэлхий дахинд Монголын нүүдлийн соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.6.2 Соёл, урлаг, оюуны болон спортын төрлөөр дэлхийд танигдсан Монгол брэндийг дэмжиж, Монгол бахархлыг төлөвшүүлнэ.
- 1.6.3 Түүх, соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.
- 1.6.4 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- 1.6.5 Иргэд, олон нийтэд зориулсан усан бассейн бүхий спорт цогцолборыг барьж ашиглалтанд оруулна.
- 1.6.6 Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, сум бүрд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.
- 1.6.7 Шигшээ багийн спортын төрөл, бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж, тамирчид амжилтаа ахиулан, улс, тив, дэлхийн түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөгжилд хөтлөх мега төсөл, хөтөлбөрүүд

Стратегийн чанартай уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийг хэрэгжүүлнэ.

- 2.1.1 Алтай хотод баригдах дулааны станцыг ашиглалтад оруулж, 2 дугаар хэлхээний шугам сүлжээг бүрэн шинэчилж, хэрэглээний халуун, хүйтэн устай болгоно.
- 2.1.2 Төгрөг сумын Хүрэн голын нүүрсний ордыг түшиглэн Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.3 Тайшир сумын Дөрвөлжингийн шохойн чулууны ордыг түшиглэн жилд 360 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.
- 2.1.4 Тайшир сумын төмрийн хүдрийн ордыг түшиглэн баяжуулах үйлдвэр байгуулан экспортлох ажлыг эхлүүлнэ.
- 2.1.5 Алтай хотод 10МВт-ын нарны цахилгаан станц барьж ашиглалтад оруулна.
- 2.1.6 Инженерийн цэргийн анги байгуулна.



2.1.7 Тайшир сумын нутагт орших ордыг түшиглэн чулууны үйлдвэр байгуулна


2.2. Эдийн засийн төрөлжилт

Мал аж ахуй, газар тариалан

- 2.2.1 Сумдын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбарыг тодорхойлж, тээвэр логистикийн сүлжээг хөгжүүлнэ.
- 2.2.2 Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.
- 2.2.3 Ноос, ноолуурын анхан шатны боловсруулалт хийх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжинэ.
- 2.2.4 Мал эмнэлгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, малын эмч, зоо-техникчдийг бэлтгэж, орон нутагт ажиллуулна.
- 2.2.5 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй, тайван бүс болох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.2.6 Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын сүүний хэрэгцээг бүрэн хангана.
- 2.2.7 “Атар-4” аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.2.8 Хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 2.2.9 Газар тариалангийн бүс нутагт усжуулалтыг нэмэгдүүлж, үрийн шилмэл сортын нөөц бүрдүүлнэ.
- 2.2.10 ХАА-н даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.
- 2.2.11 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.
- 2.2.12 Дэлгэр сумын Гуулин тосгоны газар тариалангийн бүс нутгийг түшиглэн Ухаалаг Хөдөө Аж Ахуй, Хүлэмжийг парк байгуулна.
- 2.2.13 Шарга сумд “Хармаг” төслийг хэрэгжүүлж байгалийн ашигт ургамлыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 2.2.14 Услалтын системүүдийн цахилгааны асуудлыг шийдвэрлэж, усалгаатай газар тариаланг хөгжүүлнэ.

Хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлал

- 2.2.15 Говь-Алтай аймгийн ногоон хөгжлийн бодлогыг боловсруулж, аймгийн хэмжээнд байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээг дэмжинэ.
- 2.2.16 “Ногоон–Алтай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Алтай хотын болон сумдын төвийн ногоон байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 2.2.17 Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарыг тэргүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.
- 2.2.18 Аялал жуулчлалын гол маршрутыг шинэчлэн батлаж, цахилгаан хангамж, авто замын дэд бүтцийг сайжруулна.
- 2.2.19 Хүнхэр, Гэгээн нуур, Ээж хайрхан, Сутай хайрханыг түшиглэсэн Эко болон экистрем аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.2.20 Хүнхэр амралтын газар, “Хөгжилтэй андууд” хүүхдийн зуслан, Бигэрийн “Таван элс” бөөр сувилал зэрэг амралт сувиллын газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.



Төр, хувийн хэвшлийн түншлэл


- 2.2.21 Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын 2020-2024 оны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна.
- 2.2.22 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлж, аж үйлдвэрийн парк байгуулах орон нутгийн шийдвэрийг гаргаж, шийдвэр гаргах байгуулагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.2.23 Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжинэ.
- 2.2.24 Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагддаг тусгай зөвшөөрөл, гарын үсгийн тоог цөөрүүлж, хугацааг уртасган, давхардсан хяналт, шалгалтыг арилгах бодлогыг дэмжин ажиллана.
- 2.2.25 Алтай нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнесээ эрхлэх ур чадвар, санхүүгийн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулж зөвлөг туслах үйлчилгээг үзүүлнэ.
- 2.2.26 Ноос, ноолуурын анхан шатны боловсруулалт хийх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжинэ.
- 2.2.27 Барилгын материал үйлдвэрлэлийг салбарыг бодлогоор дэмжиж барилга үйлдвэрлэлийн төрөлжсөн бригадуудыг бий болгож чадавхижуулах ажлыг МСҮТ болон аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ

2.3 Дэд бүтцийн сүлжээ

- 2.3.1 Алтай хотод Автовокзалын барилгыг шинээр ашиглалтад оруулж тээврийн үйлчилгээг сайжруулна.
- 2.3.2 Алтай хотын төвийн цэвэр ус, ариутгах татуургын төв болон салбар шугамыг шинэчилж саарал усны технологийг нэвтрүүлнэ.
- 2.3.3 Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинээр суурьшлын бүсүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хот төлөвлөлтийг сайжруулна.
- 2.3.4 Алтай хотын үерийн байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.3.5 Алтай хотод олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж инженерийн хангамжтай орон сууцаар хангана. Үүнд:
 - А. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл-500 өрх
 - Б. Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл-800 өрх
 - В. Шинэ суурьшлын бүс хөгжүүлэх төсөл-800 өрх
 - Г. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулах төсөл-100 өрх
- 2.3.6 Сумын хөгжил хөтөлбөрийн хүрээнд жишиг сумын төвүүдийг шинээр бий болгоно.
- 2.3.7 Төвлөрсөн инженерийн байгууламжийг сумдад бий болгож, иргэдийг тохилог орон сууцаар хангах ажлын хүрээнд сум бүрт 20 айлын орон сууц барих ажлыг эхлүүлж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Эрчим хүчний төсөл

- 2.3.8 Нүүрсний ордуудыг түшиглэн шахмал түлшний үйлдвэр барьж, аймаг, сумын төвийн агаарын бохирдлыг бууруулна.
- 2.3.9 “Алтай” 50 МВт-ын салхин цахилгаан станцын барих хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.



- 2.3.10 Алтай хотын цахилгаан эрчим хүчний цагийн ялгавартай тарифыг хэрэгжүүлж, иргэдийн өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлнэ. Аймаг, сумын төвийн 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл шинэчлэл хийж, гэр хорооллын шинэ суурьшлын цахилгаан хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.
- 2.3.11 Бүх сумын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болгож инженерийн шугам сүлжээг шинээр бий болгоно.
- 2.3.12 Алтай сумын нарны цахилгаан станцыг өргөтгөж, 24 цагийн цахилгаан хангамжийн найдвартай эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

Агаарын тээвэр

- 2.3.13 Сум, хот хоорондын зорчигч тээврийн арилжааны тогтмол нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлж, агаарын тээврийг хөгжүүлнэ.
- 2.3.14 Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, өрсөлдөөнийг дэмжих замаар нислэгийн үнийг хямдруулна.
- 2.3.15 Алслагдсан Алтай сум, Бугат сумын Тахийн Тал, Цогт сумын Баянтоорой тосгонд бага оврын агаарын тээврийг нэвтрүүлнэ.

Авто зам


- 2.3.16 Авто замын сүлжээг өргөтгөн 300 км-ээс багагүй урт авто зам шинээр барина.
- 2.3.17 Алтай хотын авто замуудыг ус зайлуулах шугамтай холбох ажлыг хийнэ.
- 2.3.18 Алтай-Бургастай чиглэлийн 320 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлнэ.
- 2.3.19 Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлнэ.
- 2.3.20 Дэлгэр, Хөхморьт, Баян-Уул, Дарви, Бигэр зэрэг сумдыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлнэ.

2. 4. “Алтайн баялгийн сан”

- 2.4.1 Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.
- 2.4.2 “Алтайн баялгийн сан”-гаас орон нутгийн хөгжил, нийгмийн салбарт хөрөнгө оруулалтыг хийнэ.

2.5. Гадаад харилцаа хамтын ажиллагаа

- 2.4.1 ОХУ, БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хамтран хэрэгжүүлнэ.
- 2.4.2 Бүс болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд олон улсын болон дотоодын аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 2.4.3 Гуравдагч хөрш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж, худалдааг өргөжүүлэх хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлнэ.



ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Шударга ёсны засаглал

Төрийн албаны ёс зүй, зарчим, хэм хэмжээг мөрдөж ажилладаг ашиг сонирхлоос ангид төрийн үйлчилгээг хөгжүүлнэ.

- 3.1.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 3.1.2 Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлага төлөвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулах эдийн засгийн болон бусад хөшүүргийг бий болох.
- 3.1.3 Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачлага, оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

3.2. Цахим Алтайчууд – хүнд сурталгүй төрийн үйлчилгээ


Төрийн албаны ёс зүй, зарчим, хэм хэмжээг мөрдөж ажилладаг ашиг сонирхлоос ангид хөнгөн шуурхай төрийн үйлчилгээг хөгжүүлнэ.

- 3.2.1 Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн тогтолцоог хөгжүүлж, цахим технологид суурилсан нэг цэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.2 Алтай сум, Баянтоорой тосгоныг өндөр хурдны интернетийн шилэн кабелийн сүлжээнд холбож, интернетийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэнэ.
- 3.2.3 Өндөр хурдны телевизийн сигнал дамжуулах "IPTV" технологи /Юнивишн үйлчилгээ/-г сумдад нэвтрүүлнэ.
- 3.2.4 Оюуны хөдөлмөрийг дэмжсэн онлайн, зайнаас ажиллах ажлын байрыг нэмэгдүүлнэ
- 3.2.5 Сумдын Засаг даргын Тамгын газрын болон багийн төвийн барилгыг шинээр барьж, засварлан тохижуулж, багийн Засаг дарга нарыг унаажуулна.
- 3.2.6 Сумын хөгжлийг дэмжиж, хоёроос доошгүй сумыг "Жишиг сум"-ын хэмжээнд хүргэнэ.

3.3. Мэргэшсэн ёс зүйтэй төрийн алба

Төрийн албаны олон улсын стандартыг хангасан, чадварлаг боловсон хүчинтэй төрийн үйлчилгээг хөгжүүлнэ.

- 3.3.1 Төрийн албанд ISO стандартыг нэвтэрүүлэх ажлыг эхлүүлж, төрийн албан хаагчдын хариуцлага, ёс зүйг дүгнэх иргэдийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 3.3.2 Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх тэтгэлэгт хөтөлбөр, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.3.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний цар хүрээг нэмэгдүүлж, төрийн байгууллагын ажлын үр дүнг дээшлүүлнэ.
- 3.3.4 "Алтайн боловсон хүчин" бодлогыг хэрэгжүүлж төрийн албыг ахмад, дунд, залуу үеийн алтан хэлхээгээр холбож чадавхижуулна.
- 3.3.5 Аймгийн Засаг Даргын Тамгын Газарт болон тохируулагч агентлагт тухайн салбартаа 5-аас дээш жил ажилласан мэдлэг боловсрол ёс зүйтэй албан



хаагчдыг авч ажиллуулан төрийн албаны нэр хүндийг дээшлүүлж хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээг бий болгоно.

- 3.3.6 Төрийн байгууллага, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. Баталгаат ундны ус


- 4.1.1 “Тайшир-Алтай” төслөөр хэрэгжиж буй ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, хамгаалалтын өргөтгөж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.
- 4.1.2 Гадаргын усны урсацыг сайжруулж, хөв цөөрөм байгуулах, говийг усжуулах төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 4.1.3 Цэвэр усны тухайд 47 км шугамыг хос шугамтай болгон, ундны ус болон ахуйн хэрэглээний усыг ялгаж хэрэглэж хэвшүүлэх. Ундны усны шугамыг зэс шугамтай болгох.
- 4.1.4 Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийх замаар ундны усны чанар сайжруулах ажлыг зохион байгуулна.

4.2. Хариуцлагатай уул уурхай

- 4.2.1 Уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 4.2.2 Уул уурхайн нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 4.2.3 Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, байгалийн нөөц ашигласан төлбөрөө хугацаандаа төлдөг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 4.2.4 Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чандлан мөрдөнө.

4.3. Хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт

- 4.3.1 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.3.2 Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.
- 4.3.3 “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж, уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж дахин ашиглах боломжтой болгоно.
- 4.3.4 Байгаль орчны шинжилгээний төв лабораторийг шинэчилж, хөрс, ундны ус, агаарын бохирдлын хяналт, шинжилгээг сайжруулна.
- 4.3.5 Монгол орны нөхцөлд зориудаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийнэ.
- 4.3.6 Цөлжилтийг бууруулж, бэлчээрийг доройтлоос сэргийлнэ.
- 4.3.7 Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 4.3.8 Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэргч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.



- 4.3.9 Бэлчээрийн доройтлыг бууруулах газар зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээнэ.
- 4.3.10 Бэлчээрийг нөхөн сэргээх “Малчдын дундын сан”-г сум бүрд бий болгоно.

4.4. Ногоон эдийн засаг – Эко Алтайчууд

- 4.4.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгож, байгальд халгүйгээр хадгалах, савлах технологийг дэмжинэ.
- 4.4.2 Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.
- 4.4.3 Байгаль орчинд ээлтэй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд тав тухтай зорчих орчныг бүрдүүлнэ.
- 4.4.4 “Дугуйн зам” хөтөлбөрийг боловсруулж, Алтай хотод 5 км, сумдад тус бүр 1 км дугуйн замыг шинээр барина.
- 4.4.5 Ундны ус шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, аймгийн нийт амын ундны усны эрүүл ахуйг стандартыг бүрэн хангуулж сумдад ухаалаг худгийн тоог нэмэгдүүлнэ.
- 4.4.6 Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бэлчээрийг нөхөн сэргээх “Малчдын дундын сан”-г сумд бий болгоно.
- 4.4.7 Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон, муу усны нүхийг барьж, ашиглах хөдөлгөөн өрнүүлж ажиллана.


ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Амьдралын таатай орчин бүхий ногоон Алтай

- 5.1.1 Хот суурин газрын хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх, устгах, булах үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлнэ.
- 5.1.2 “Ногоон–Алтай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Алтай хотын болон сумдын төвийн ногоон байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.2. Эдийн засгийн бүсчилсэн хөгжил

- 5.2.1 Сумдын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбарыг тодорхойлж, тээвэр логистикийн сүлжээг хөгжүүлнэ.
- 5.2.2 Сумдын төвүүдийг (Дэлгэр, Хөхморьт, Баян-Уул, Дарив, Бигэр) улсын чанартай хатуу хучилттай авто замд холбох ажлыг эхлүүлж хэрэгжүүлэх
- 5.2.3 Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах органик хүнс үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлэх
- 5.2.4 Тайшир сумын Дөрвөлжингийн шохойн чулууны ордыг түшиглэн жилд 360 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.
- 5.2.5 Төгрөг сумын Хүрэн голын нүүрсний ордыг түшиглэн Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлнэ.



- 5.2.6 Тайшир сумын төмрийн хүдрийн ордыг түшиглэн баяжуулах үйлдвэр байгуулан экспортлох ажлыг эхлүүлнэ.
- 5.2.7 Алтай-Бургастайн чиглэлийн 320 км болон Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах ажлыг эхлүүлнэ.
- 5.2.8 Алслагдсан Алтай сум, Бугат сумын Тахийн Тал, Цогт сумын Баянтоорой тосгонд бага оврын агаарын тээврийг нэвтрүүлнэ.

5.3 Аймгийн хөгжил сумаас

5.3.1 Алтай сум

1. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангана.
2. Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам цэвэрлэх байгууламж байгуулах
3. Урт багт үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлэх
4. 12-р жилийн дунд сургуулийн хичээлийн өргөтлийн барилгын ажлыг барих
5. 24 айлын орон сууцыг барих

5.3.2 Баян-Уул сум


1. ЗДТГ-ын шинэ байрны зураг төсвийг хийж, ашиглалтад оруулах
2. Сумын төвийг шинэ суурьшлын бүс болон хуучин шугамын нийт 1500м 0,4 квт цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх
3. Мал нядлах, хөргөх, хөлдөөх цехийн барилгыг барьж, дэд бүтцийг хийх
4. Алтан гадас багийн төвийг 10 Кв-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох
5. Баянговь багийн нутагт 20-30 га газрын услалтын систем байгуулах

5.3.3 Бугат сум

1. Бугат сумын төвийг босоо тэнхлэгийн Алтай- Бургастайн боомтыг холбосон хатуу хучилттай замтай холбох
2. ЗДТГ-ын хуучин барилгыг их засварт оруулж Ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглах
3. Тахийн тал, Биж багийн цахилгаан хангамжийг сайжруулах
4. Алтай өвөр говь, Биж, Ферм багийн айл өрхийг хамрах үүрэн холбооны сүлжээ тавих
5. Сумын төвийн спорт заалны их засвар хийх

5.3.4 Бигэр сум

1. ЗДТГ-ын барилга шинээр барих
2. Бигэр сумыг аймгийн төвтэй засмал замаар холбох
3. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэх зорилгоор услалтын систем засварлах тоног төхөөрөмжөөр хангах
4. Ариутгал халваргүйжүүлэлтийн тусгай зориулалтын машин техниктэй болох / Дүк машин/
5. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баяр наадмын талбайг шинээр барих



5.3.5 Дарив сум

1. Жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, Хүүхэд залуучууд, ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх “Хүний хөгжлийн ордон” барих
2. Хүйсийн говиос сумын төв орох 54 км хатуу хучилттай зам тавих
3. 24 айлын орон сууц барих
4. Сумын төвд хүүхдийн парк барих
5. Ихэс багийн төвийг 10 Кв-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох

5.3.6 Дэлгэр сум

1. Дэлгэр сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай замаар холбох
2. Гуулин тосгоны захирагчийн ажлын албаны байрны зураг төсвийг хийж ашиглалтад оруулах
3. Нэгдсэн халаалтын системтэй болох
4. Шинэ суурьшлын байгуулж, дэд бүтцийн асуудлыг шийдэх
5. Сумын төв болон Гуулин тосгонд стандарт нийцсэн ухаалаг худаг байгуулах

5.3.7 Жаргалан сум


1. Бүрэн багт Завхан гол дээр гүүр барих
2. Аймгаас Жаргалан явдаг дунд замыг тавих
3. Жилд хоёроос доошгүй /худаг, хөв/ уст цэг байгуулах
4. Цахирын услалтын системийг сэргээж үйл ажиллагааг эхлүүлэх
5. Цахирын услалтын системийг түшиглэн өвс тэжээлийн бага оврын үйлдвэр барих

5.3.8 Тайшир сум

1. ЗДТГ, сургуулийн их засварын ажлыг хийх
2. Бэлчээр хамгаалах чиглэлээр үлийн цагаан оготно устгах, баг бүрт 2 худаг гаргах
3. Шинээр Эрүүл мэндийн төв барих
4. Сумын төвийн цэвэр бохир усны шугам сүлжээ барих
5. Газар тариалан, аялал жуулчлалын чиглэлээр Хуримтын услалтын систем болон Нарбанчин гэгээнтний туурийн чиглэлд цахилгаан дамжуулах шугам татах

5.3.9 Тонхил сум

1. 12-р жилийн дунд сургуулийн хичээлийн барилгын зураг төсвийг хийж, барилгыг барих
2. Сумын төвийг нэгдсэн халаалтанд холбох
3. Сумын төв дотор засмал зам барих
4. Мах, сүү боловсруулах үйлдвэр барих
5. Ахмадын өргөө барих



5.3.10 Төгрөг сум

1. Төгрөг сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай замаар холбох
2. 12 км цэвэр усны шугам хоолой тавих
3. 12-р жилийн дунд сургуулийн хичээлийн барилгын зураг төсвийг хийж, барилгыг барих
4. Сумын төв доторх засмал зам
5. Ахуйн үйлчилгээний ордон барих

5.3.11 Цогт сум

1. ЗДТГ-ын шинээр байр барих
2. Төгрөг, Далан багт мал усалгааны худаг барих
3. Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам цэвэрлэх байгууламж байгуулах
4. Ахуйн үйлчилгээний ордон барих
5. Баянтооройн услалтын системийг түшиглэж малын тэжээлийн үйлдвэр барих

5.3.12 Цээл сум

1. 12-р жилийн дунд сургуулийн хичээлийн барилгын зураг төсвийг хийж, барилгыг барих
2. ЗДТГ-ын шинэ байрны зураг төсвийг хийж, ашиглалтад оруулах
3. Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам цэвэрлэх байгууламж байгуулах
4. Сумын төв доторх засмал зам
5. Сургуулийн 100 хүүхдийн дотуур байрыг барих

5.3.13 Чандмань сум


1. ЗДТГ-ын шинэ байрны зураг төсвийг хийж, ашиглалтад оруулах
2. Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам цэвэрлэх байгууламж байгуулах
3. Сумын төв доторх засмал зам
4. Спорт заал шинээр барих
5. Соёлын төвийн засвар

5.3.14 Халиун сум

1. Тариалан эрхлэгчдийг орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжийг шинэчлэх
2. Малчдын бэлчээрийн усан хангамжийг сайжруулах 4 багт
3. Олон булаг багт бага сургууль, цэцэрлэгийн комплекс барих
4. Нийт малчдын мал угаалгын ванн болон зөөврийн хашаагаар хангах
5. Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгох

5.3.15 Хөхморьт сум

1. Хөхморьт сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай замтай холбох .
2. Баяр наадмын талбайг шинэчлэн сэргээн засварлах
3. Соёлын төвийн барилгыг их засвар оруулах.
4. Цоохор нуур багийн нутагт үүрэн холбооны сүлжээг ашиглалтанд оруулах.



5. Сургууль, цэцэрлэгийг бүрэн камержуулж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлнэ.

5.3.16 Шарга сум

1. Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам барих
2. Спортын цогцолбортой болох
3. ЗДТГ-ын байр шинээр барих
4. Ингэний ундаа савлах, боловсруулах, тэжээлийн үйлдвэр байгуулах
5. Үйлчилгээний төв байгуулах

5.3.17 Эрдэнэ сум

1. 12-р жилийн дунд сургуулийн хичээлийн барилгын зураг төсвийг хийж, барилгыг барих
2. Эрүүл мэндийн төвийг хүүхдийн тасагтай болгох
3. Дулааны шугам солих, төвийн цэвэр усны тогоог томсгох
4. Хогийн нэгдсэн цэгтэй болж стандартын шаардлагыг хангуулах
5. Гэр хороололд шугам татах.

5.3.18 Есөнбулаг сум

1. 3500 хүний суудалтай төв цэнгэлдэх хүрээлэн ашиглалтад оруулах
2. Орчин үеийн тоног төхөөрөмж тоглоом бүхий хүүхэд залуучуудын паркийг ашиглалтад оруулах
3. Гэр хороололыг цэвэр бохир усны шугамд холбох ажлыг ээлж дараатай хийж, эхний ээлжинд Баянхайрхан багийн 8,9 дүгээр гудамж, Индэрт багийн 4, 5 дугаар гудамж, Оргил багийн 23,24-р байр, 10-р гудамжны орчинд дахин төлөвлөлт хийнэ.
4. “Утаагүй хот” төслийг хэрэгжүүлж, Алтай хотын нүүрсний хэрэглээг хангах хүчин чадал бүхий шахмал түлшний үйлдвэрийг ашиглалтад оруулна.
5. Алтай хотод 5-с доошгүй хатуу хучилттай авто замыг шинээр ашиглалтад оруулж, “Дугуйн болон явган хүний зам” төслийг хэрэгжүүлж 5 км дугуйн зам, 10 км явган хүний замыг шинээр барина.
6. “Жишиг гэр хороолол” төсөл хэрэгжүүлж, иргэдийн дунд хуримтлалын бүлэг үүсгэх замаар ая тухтай амьдрах орчинг бий болгоно.
7. “Гэрэлт гудамж” төсөл хэрэгжүүлж хотын гэрэлтүүлгийг 3 дахин нэмэгдүүлнэ
8. Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжуудыг буулгаж, дахин төлөвлөлтөд оруулна.
9. Алтай хотын шинэ суурьшлын бүс Солонго хорооллын эхний ээлжийн 1000 айлын орон сууцыг ашиглалтад оруулна.
10. Стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг баг болгонд 3-с доошгүйг шинээр байгуулж хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.

